



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн
хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хавсралтад зааснаар шинэчлэн тогтоосугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан "Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хорооны 2015 оны 412 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


3. Тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагууд нь эрхлэх үйл ажиллагааны төрөл чиглэлээс хамааруулан 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг энэ тогтоолын хавсралтад заасан хэмжээнд хүргэхийг тэдгээрийн хувь нийлүүлэгчид, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийн Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭД ДАРГА  БАТБОЛД



Санхүүгийн зохицуулах хороо
2016 оны 03 дугаар сарын 14-ны өдөр
32 дугаар тогтоолын хавсра



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

№	ББСБ-ын ангилал	Эрхлэх үйл ажиллагаа	Аймгийн төвийн сумаас бусад суманд	Аймгийн төвийн сум	Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум	Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг	Улаанбаатар хотын бусад дүүрэг
1.	Валютын арилжааны	гадаад валютын арилжаа			50.0		100.0
		гадаад валютын арилжаа болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ			100.0		200.0
2.	Зээл, санхүүжилтийн		20.0	50.0	200.0	200.0	800.0
3.	Хөрөнгө удирдлагын		50.0	100.0	500.0	500.0	2,000.0

--- ooOoo ---

/сая төгрөгөө